

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

Монгол Улс дахь олон улс судлал, олон улсын харилцааны суурь судалгааг дагнан хэрэгжүүлэгч шинжлэх ухааны ууган байгууллага болох Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэнгээс жил тутам эрхлэн гаргадаг “Олон улс судлал” сэтгүүлийн ээлжит 118 дахь дугаарыг эрхэм уншигч Таны гарт өргөн барьж байгаадаа баяртай байна.

47 дахь жилдээ хэвлэгдэж буй “Олон улс судлал” сэтгүүл өдгөө уламжлалт цаасан суурьтайгаар гарахын зэрэгцээ тогтмол цахим хувилбараар уншигч олонд хүрдэг болоод цөөнгүй жилийг үдэж байна. 2023 онд манай сэтгүүл DOAJ - Directory of Open Access Journals-д¹ бүртгүүлсэн тус хүрээлэнгийн хоёр дахь сэтгүүл болсон бөгөөд өдгөө 2025 оны байдлаар www.mongoliajol.info/index.php/JIS, www.imori.ac.mn цахим хуудаснаа буй манай хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын нийт бүтээлээс дэлхий өнцөг булан бүрээс 52 мянга гаруй удаа татан авалт хийгдсэн тоон үзүүлэлттэй байгаа нь чамлахааргүй үзүүлэлт билээ. Энэ оны эхнээс манай сэтгүүлд ирүүлж хэвлүүлэх шаардлага хангасан өгүүлэл, нийтлэлүүдийг бид “online first” буюу цахим

хувилбарыг олон нийтэд шуурхай хүргэдэг болсноор энэ оны сүүлийн сарын байдлаар 1600 гаруй удаагийн хандалттай байгаа нь манай сэтгүүлийн давуу талыг илтгэн харуулахаас гадна тус сэтгүүлд бүтээлээ хэвлүүлж буй эрдэмтэн судлаачдад ч олон боломж, давуу талыг мөн олгож байгаа юм.

Түүнчлэн 2025 онд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Нийгмийн шинжлэх ухааны бага чуулганаас Монгол Улсын хэмжээнд нийгэм-хүмүүнлэгийн салбарын судалгааны байгууллага, их дээд сургуулийн нийт 51 сэтгүүлд олон улсын сэтгүүл хөгжүүлэлтийн жишиг үнэлгээг хийж үзэхэд “А” үнэлгээ авсан хоёр сэтгүүл шалгарсан нь манай хүрээлэнгийн “Олон улс судлал” болон хүрээлэнгээс англи хэлээр эрхлэн гаргадаг “Mongolian Journal of International Affairs” сэтгүүлүүд болж, олон улсын академик сэтгүүлийн шаардлагад нийцсэн үнэлгээ авч чадсан бахархалт мэдээг уншигч Та бүхэндээ дуулгахдаа баяртай байна.

2025 онд манай сэтгүүлийн редакц гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдаас ирүүлсэн 20 орчим эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэлд хөндлөнгийн хянан магадалгааг тус

¹ DOAJ нь дэлхийн өнцөг булан бүрд гарч буй эрдэм шинжилгээний нээлттэй сэтгүүлүүдийн (open access) -ийн албан ёсны бүртгэл бөгөөд чанартай агуулгуудыг нээлттэйгээр хүн бүрд хүргэх зорилготой олон улсын өргөн хүрээтэй санаачилга билээ. Одоогоор DOAJ бүртгэлд дэлхийн 133 орны 19603 эрдэм шинжилгээний сэтгүүл бүртгэлтэй байна. Дашрамд сонирхуулахад DOAJ-д Монгол Улсаас өнөөгийн байдлаар 7 эрдэм шинжилгээний сэтгүүл бүртгэгдсэн байгаа бөгөөд үүнээс 6 нь #MongoliaJOL платформын эрдэм шинжилгээний сэтгүүлүүд байна. <https://doaj.org/toc/2663-7871>

бүр хоёр удаа хийснээр энэ удаад зургаан өгүүлэл, хоёр нийтлэлийг сонгон авч та бүхэнд хүргэж байна.

Энэ удаагийн дугаарт Монгол Улсын хөгжлийн бодлого болон хөгжингүй орны эдийн засгийн хөгжлийн туршлага, бүс нутгийн аюулгүй байдал, ОХУ-Украины мөргөлдөөн, БНХАУ-аас Тайваньд явуулж буй бодлого зэрэг Монгол Улсын хөгжлийн дотоод орчин хийгээд бүс нутгийн болон олон улсын харилцааны цаг үеийн тулгамдсан асуудлын хүрээнд эрдэм шинжилгээний ач холбогдолтой өгүүлүүд нийтлэгдсэнийг онцлон тэмдэглэе.

Тухайлбал, тус хүрээлэнгийн Орос судлалын салбарын эрхлэгч, доктор Норовсамбуугийн Наранжаргалын “Алтанбулаг боомт ба чөлөөт бүсийн хөгжил: Түүхэн уламжлал ба орчин үеийн стратегийн ач холбогдол” өгүүлэлд Алтанбулаг боомт болон Алтанбулаг чөлөөт худалдааны бүсийн түүхэн хөгжил, өнөөгийн үйл ажиллагаа, стратегийн ач холбогдлыг судалж “хуурай боомт-чөлөөт бүслогистикийн интеграл төв” хэлбэрээр хөгжүүлэх нь Монгол Улсын хил орчмын эдийн засгийн бодлогын дараагийн шатны чухал зорилт болгох тухай чухал саналыг дэвшүүлжээ.

Монгол Улсаас бүс нутгийн аюулгүй байдлын асуудалд хэрхэн идэвх санаачилгатай оролцож буй талаар БНХАУ-ын Ардын их сургуулийн Олон улсын харилцааны сургуулийн докторант Ли Юшин Солонго, Бээжингийн их сургуулийн докторант Чинзайн Рэнцэн нарын “Зүүн Азийн Аюулгүй байдлын хамтын ажиллагаа ба Монгол Улсын оролцоо” өгүүлэлд бүс нутгийн аюулгүй байдалд

Монгол Улсын “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилга, цөмийн зэвсэггүй бүсийн бодлого, бүс нутгийн итгэлцлийг бэхжүүлэх дипломат үйл ажиллагааг шинжилж, манай улс энхийг дэмжих бодлогын тогтвортой байдал, яриа хэлэлцээний гүүр болох үүргийг онцолсон байна.

Мөн Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн докторант Сундуйн Чулуундорж, доктор (Ph.D) Няндагийн Ганбат нарын “Арктикийн геостратеги: Их гүрнүүдийн тоглолт болон ирээдүйн чиг хандлагын талаарх таамаглал” өгүүлэлд Арктикийн бүсийн стратегийн ач холбогдлыг АНУ, ОХУ, БНХАУ зэрэг их гүрнүүдийн өрсөлдөөний хүрээнд авч үзэж, Монгол Улс газар зүйн хувьд хамааралгүй ч судалгааны болон бодлогын түвшинд хамтран ажиллах боломжийг тодорхойлсон байна.

Бүс нутаг, олон улсын харилцааны асуудлаас гадна Монгол Улсын гадаад бодлогын “гуравдагч хөрш” Бүгд Найрамдах Солонгос Улсын эдийн засгийн хөгжлийн замналыг тус хүрээлэнгийн Гуравдагч хөрш орон судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан Дашдаваагийн Мягмар “БНСУ-ын эдийн засгийн хөгжлийн замнал: Дотоод болон гадаад орчны нөлөө” өгүүлэлдээ судалж, Монгол Улсад уг туршлагыг нутагшуулах боломж, ач холбогдлыг тодруулан гаргажээ.

Олон улсын харилцааны тогтолцоо улам бүр олон туйлт хандлага руу шилжиж буй энэ үед манай улсын хоёр хөршид тулгараад буй цаг үеийн асуудлаар хоёр өгүүлэл нийтлэгдсэн нь тус хүрээлэнгийн Орос судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан Буян-Эрдэнийн

Мөнхцэцэгийн “Гибрид дайны соёлын талбар: ОХУ-Украины мөргөлдөөний жишээн дээр” өгүүлэл болон Аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн судлаач Жамбалдоржийн Баярбаатарын “БНХАУ-аас Тайваньд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа” өгүүлэл болно.

Энэ дугаарт хэвлэгдсэн “Гибрид дайны соёлын талбар: ОХУ-Украины мөргөлдөөний жишээн дээр” өгүүлэлд соёл, урлагийн салбар нь гибрид дайн бүхий сөргөлдөөнт орчинд хэрхэн улс төрийн хэрэгсэл болон хувирч, улмаар хоёр улсын дотоод, гадаад орчныг соёлын хувьд туйлшруулж буйг дүгнэсэн бол “БНХАУ-аас Тайваньд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа” өгүүлэлд БНХАУ-аас Тайваньд хэрэгжүүлж буй бодлогын өөрчлөлт, ялангуяа “Тайванийг энх тайвнаар нэгтгэх” үйл ажиллагааг онолын үндэслэлтэй авч үзэн, хэрэгжүүлж буй арга хэлбэр, Тайванийн хариу үйлдэл, тэдгээрт нөлөөлөх дотоод, гадаад хүчин зүйлийг шинжилсэн байна.

Түүнчлэн манай сэтгүүлийн “Нийтлэл” хэсэгт энэ удаад хоёр нийтлэл багтсан бөгөөд эхнийх нь Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, профессор Дашдоржийн Баярхүүгийн ХХ зуунд тохиосон Хүйтэн дайн, түүнд тухайн цагийн БНМАУ ямар үүрэг, оролцоотой байсан талаар бол удаах нь Баргын нутгаас Монголд шилжин ирж, БНМАУ-ын Боловсролын яаманд хэлтсийн даргаар ажиллаж байсан Эрдэмбилэгийн дурсамжийн тухайд тус хүрээлэнгийн ЭШТА, (Sc.D),

профессор Оохнойн Батсайханы бичсэн нийтлэлийг уншигч Танаа хүргэж байна. Барга Эрдэмбилэг нь ХХ зууны 1920-иод оны Баргын хувьсгалт хөдөлгөөн, 1928 оны Баргын бослогод оролцсон үйл явдал, Зөвлөлт Холбоот Улсад суралцсан үеийн дурсамж, улмаар Боловсролын яаманд ажилласан үе хийгээд баривчлагдан хэлмэгдсэн түүхээ өөрийн дурсамждаа тод, амьд өгүүлэмжээр хүүрнэжээ.

Төгсгөлд нь бид “Шинэ ном” буландаа та бүхэн манай хүрээлэнгээс энэ онд шинээр хэвлэгдэн гарсан зарим бүтээлийн дээжээс танилцууллаа.

Манай сэтгүүлийн энэхүү дугаарт судалгааны өгүүлэл, нийтлэлээ ирүүлсэн эрдэмтэн судлаачид болон үнэт цаг заваа харамгүй зориулан бодит шүүмжийг ирүүлсэн нийт шинжээч эрдэмтэд болон Редакцын зөвлөлийн гишүүддээ Ерөнхий эрхлэгчийн зүгээс гүн талархал илэрхийлж байна.

“Олон улс судлал” сэтгүүлийн 2026 оны дугаарт эрдэм шинжилгээний өгүүллээ хэвлүүлэх хүсэлтэй эрдэмтэн судлаач Та бүхэн <https://mongoliajol.info/index/user/register> хуудсанд өөрийн нэрээр эрх үүсгэн бүртгүүлж, судалгааны бүтээлээ илгээж болохын зэрэгцээ сэтгүүлийн талаарх санал, сэтгэгдлээ mjis@mas.ac.mn цахим шуудангаар ирүүлбэл бид талархан хүлээн авах болно.

*Ерөнхий эрхлэгч
Дашнямын Золбоо, доктор (Ph.D), дэд
профессор*

*Нарийн бичгийн дарга
Болдын Хишигжаргал (МА)*